


2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Манай орны 11 дүгээр сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар -13°C (55.4°F) –аас хүйтэн, говь цөлийн бүс нутгаар -3.0°C (26.6°F) –аас 0°C (32.0°F), бусад нутгаар -12.0°C –аас -3.1°C (10.3°F –аас 26.4°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 11 дүгээр сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 2.0 хувь нь ордог. Тус сард нутгийн хойд болон зүүн хэсгээр 5.0-15 мм, бусад нутгаар 0.3-5 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 11 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны оронзайн тархалт


2025 оны 11 дүгээр сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -2.3°C -аар хүйтэн, ОЖД-аас $+1.5^{\circ}\text{C}$ -аар дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 15 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 64.3% нь дунджаас 1.1°C -ээс 4.3°C -аар дулаан, 27.9% нь дунджийн орчим, 7.8% нь дунджаас хүйтэн байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 8.9 мм тунадас орсон ба өмнөх жилээс 2.5, ОЖД-аас 2.2 дахин их тунадас орсон бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 3 дахь их тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн ихэнх буюу 81.4% нь дунджаас ахиу, 7.8% нь дунджийн орчим, 10.8% нь дунджаас бага тунадас орсон байна.




Зураг 2. 2025 оны 11 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 11 дүгээр сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) сарын турш нийт 3 удаа хүйтрэлт ажиглагдсан байна. Үүнээс хамгийн эрчимтэй хүйтрэлт нь 2 дугаар 10 хоногийн дундаас сүүл хүртэл тохиож, зүүн бүсээс бусад нутгуудад ОЖД-аас -4°C -аас -8°C -аар хүйтэн байв. Харин бусад хугацаанд буюу сарын ихэнх өдрүүдэд нийт нутгаар ОЖД-аас $+0.5$ -ээс $+8.7^{\circ}\text{C}$ -аар дулаан байсан. Хур тунадасны хувьд нийт нутгаар харьцангуй ахиу хур тунадас орсон. Ялангуяа 1 дүгээр 10 хоногийн 6-аас 8-ны өдрүүдэд хур тунадас их хэмжээгээр орсон бол 3 дугаар 10 хоногт хур тунадастай өдрийн тоо их байжээ..



Зураг3. Хоногийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Өмнөговь аймгийн Ханбогд суманд 15.4°C , үнэмлэхүй бага утга Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -39.9°C хүрчээ. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийнголд 27°C , үнэмлэхүй бага утга Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -44°C хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн ихдээ Сэлэнгэ аймгийн Орхон суманд 7-ний өдөр 17.1 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 972.6гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 761.6гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Говь-Алтай аймгийн Бугат суманд 31м/с хүрчээ.



Зураг 4. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд